

Хянасан: 2012 оны 3-р сар

Хэрэглэхийн өмнө энэхүү зааврыг анхааралтай уншина уу. Танд дахин унших шаардлага гарч болзошгүй тул зааврыг хадгална уу.

Ангилал: 3 ОТС

**Булчин болон мэдрэлийн өвдөлтийг намдаагч, үрэвслийн эсрэг
бэлдмэл**

ОМИ БРОДЕРХҮҮД МЕНТАРМ Кю ТОСОН ТҮРХЭЦ

Жоргүй олгоно

**Analgesic anti inflammatory agent
ОМИ BROTHERHOOD MENTURM Q OINTMENT**

Хадгалах нөхцөл: Хуурай, сэрүүн газарт нарны тусгалаас хамгаалж хадгалаана.

Хадгалах хугацаа: 5 жил

- Булчингийн өвдөлт ба үе мөчний өвдөлтийн эмчилгээнд хэрэглэх, илааршуулах иллэгийн тосон түрхэц.
- OMI BROTHERHOOD MENTURM Q тосон түрхэц нь метилсалицилатыг агуулж, арьсан доорх судсанд амархан нэвтэрч, үрэвслийн эсрэг үйлчлэл үзүүлж, өвдөлтийг намдаадаг. Өөр нэгэн найрлага болох ментол нь загатнааг намдаан, сэрүүцүүлэх мэдрэмж төрүүлж, хэсэг газарт нөлөөлөн гипозестези үүсгэнэ.
- OMI BROTHERHOOD MENTURM Q тосон түрхэц нь анхилуун үнэртэй, наалдахгүй, даавуунд толбо үүсгэдэггүй, хуурайшилт үүсгэдэггүй, чийгшүүлэгчтэй, цагаан өнгөтэй тос юм. Хэрэглэх үед арьсанд бүрэн шингэнэ.

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ

Үе мөчний ба хэрх өвчний өвдөлт, гэмтлийн өвдөлт, мэдрэлийн өвдөлт, үений үрэвсэл, булчингийн бэртэнгэт өвдөлт, шөрмөс ба холбоосны өвдөлт, хүзүү хөших, нуруу, ууцаар өвдөх, шүд өвдөх, цээжний хэсгээр өвдөх, загатнах, гүйлсэн булчирхайн үрэвсэл, толгой өвдөх, булчин өвдөх, ядарч хөших үед хэрэглэнэ.

ТУН БА ХЭРЭГЛЭХ АРГА

ОМИ BROTHERHOOD MENTURM Q тосон түрхцийг хөшингө ба өвдөлтийг намдаах хэмжээгээр хэрэглэнэ. Шаардлагатай хэсэгт өдөрт 3-4 удаа түрхэнэ. Тосон түрхцийг арьсанд шингэтэл нь зөөлөн иллэгийг сайтар хийнэ.

<Тун ба хэрэглээтэй холбоотой болгоомжлол>

- (1) OMI BROTHERHOOD MENTURM Q тосон түрхцийг зааврын дагуу хэрэглэнэ.
- (2) Бэлдмэл нүдэнд орохоос болгоомжлох хэрэгтэй. Хэрэв нүдэнд орвол нүдээ хүйтэн эсвэл бүлээн усаар угаана. Хэрэв ноцтой шинж тэмдэг илэрвэл нүдний нарийн мэргэжлийн эмчид хандан тусламж авах хэрэгтэй.
- (3) Эцэг эхийн буюу асран хамгаалагчийн хяналтан дор хүүхдэд хэрэглэнэ.
- (4) OMI BROTHERHOOD MENTURM Q тосон түрхцийг зөвхөн гадуур түрхэж хэрэглэнэ. Тосон түрхцийг түрхээд боолт хийх, эмнэлгийн самбайгаар бүтээвэл арьсыг хэт цочроож түлж болзошгүй тул гадуур нь бүтээх, боолт хийх зэргийг хийж болохгүй.
- (5) Усанд орсны дараа бэлдмэлийг хэрэглэх нь үр дүнтэй боловч, таны арьсыг цочроож болзошгүй.

НАЙРЛАГА БА ОРЦ

Үндсэн бодис	Метилсалицилат (метил 2-гипроксibenзоат) 12% L-Ментол (5-метил-2-пропан-2-ил-циклогексан-1-ол) ... 6% Эвкалиптийн тос 2% Турпентиний тос 1.5%
Туслах бодис	Цэвэршүүлсэн ланолин, стеарил алкохол, шингэн парафин, стеарины хүчил, глицерил моностеарат, триэтаноламин, пропилен гликол, натрийн кармеллоз, анхилуун үнэртүүлэгч, силикон тос.

ЭМЧИЛГЭЭНИЙ АШИГТАЙ ҮЙЛДЭЛ

Булчин ба үе мөчний өвдөлтийг болон мөн хөшингөнөөс үүдэлтэй өвдөлтийг намдаах.
Өвдөлт ба загатнааг намдаах.
Өвдөлтийг намдааж цусны эргэлтийг дэмжих.

АНХААРУУЛГА БА БОЛГООМЖЛОЛ

Дараах зүйлсээс болгоомжлох (эсвэл шинж тэмдэг арилахгүй буюу илааршихгүй, эсвэл гаж нөлөө илэрвэл):

ОМI BROTHERHOOD MENTURM Q тосон түрхлэгийг дараах хэсэгт түрхэхийг хориглоно:

- (1) Нүд буюу нүдний салст бүрхэвч.
- (2) Намарс (экзем), тууралт, ил шархтай бол.

ШААРДЛАГАТАЙ ЗӨВЛӨМЖҮҮД

1. Хэрэглэхийн өмнө эмч, эм зүйчээс зөвлөгөө аваарай.
 - (1) Хэрэв Та эмнэлэгт эмчийн хяналтад байгаа бол;
 - (2) Хэрэв Та аль нэгэн эмэнд харшлын урвал илэрч байсан бол;
 - (3) Хэрэв Та чийглэг намарс (экзем) ба арьсны эмгэгшилтэй бол;
2. Хэрэв дараах шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрвэл хэрэглэхээ даруй зогсоож, эмч, эм зүйчээс зөвлөгөө аваарай.
3. Хэрэв нөхцөл байдал 5-6 хоногийн дотор сайжрахгүй бол хэрэглэхээ зогсоож эмийн заавартай танилцан, эмч, эм зүйчээс зөвлөгөө авна уу.

Байрлал	Шинж тэмдэг
Арьс	Тууралт, улайх, загатнах

ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ, ХЭРЭГЛЭХ ҮЕИЙН АНХААРУУЛГА

- (1) Өөрийн савлагаанд нь сайтар таглан, хуурай, сэрүүн газарт нарны гэрлээс хамгаалж хадгална.
- (2) Хүүхэд хүрэхгүй газарт хадгална.
- (3) Буруу хэрэглэх ба чанар алдагдахаас сэргийлэх үүднээс өөрсөнд хийж болохгүй.
- (4) Хүчинтэй хугацаа дууссан бэлдмэлийг хэрэглэж болохгүй. Хүчинтэй хугацаа дуусаагүй үед ч гэсэн таглааг нээсэн тохиолдолд аль болох удаахгүйгээр хэрэглэвэл зохино.

САВЛАГАА

65гр шахдаг саванд, 430гр полиэтилен савлагаатай.

Үйлдвэрлэгч ба Түгээгч:

ОМИБРОДЕРХҮҮД, ЛТД.
29 мото, Уваи-Чо, Оминачиман хот, Шига
ЯПОН УЛС